

“ЗАРИГ.МН”-ИЙ ЗАРИМДАГЛАЛ

Б.Болд-Эрдэнэ\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, сэтгүүл зүйн доктор (Ph.D)

**Түлхүүр үгс:** зариг.мн, ярилцлага, нийгмийн сүлжээ, сэтгүүл зүйн үүрэг, ёс зүй, үр нөлөө, төөрөгдүүлэлт, хандалт

**Н**ийгмийн сүлжээний хэрэглээн ний эрс өсөлт, нөлөөллийн цар хүрээ эрчтэй, хүч түрэн тэлж буй шалтгааныг мэдээллийн сайтын орчинд өрнөж буй хэрэглэгчийн хандалтын тооны төлөөх өрсөлдөөний үйл явц, жишээгээр тайлбарлаж болно. Энэхүү өрсөлдөөн нь нэг талаас сайтын хэрэглэгчдийн анхаарлыг татахуйц дуулиан шуугиан, заримдаа бүр хүний хувийн амьдралыг дэлгэсэн ил, далд бичлэгийг нийгмийн сүлжээнд байршуулах, нөгөө талаас олон нийтийн санаа бодлын төвд буй зөрчил дагуулсан асуудал, үйл явдлын хүрээнд худал, төөрөгдүүлэлтийн мэдээ түгээх зэрэг ёс зүйгүй үйлдэлд хөтөлж байна. Түүнчлэн хувийн амьдралдаа учирч буй бэрхшээл зовлонгоо төр засаг, эсвэл хэн нэгэн ивээн тэтгэгчээр шийдүүлэх гэсэн зарим хүний ч сонирхол хүсэл мэдээллийн сайтад хандах идэвх, тоог өсгөж буйн зэрэгцээ улс төрчдийн явцуу эрх ашгаа хөөсөн “захиалгат санхүүжилт” ч багагүй хувь нэмэр оруулж байгаа билээ. Ийнхүү нийгмийн сүлжээг тойрсон “сайтын тооны төлөөх өрсөл-

дөөн-хэрэглэгчийн хувийн асуудлаа шийдүүлэх гэсэн явцуу хүсэлт-улс төрчдийн далд санхүүжилт” гэсэн хандалтаар хөөрөгсдийн давлагаа нь олон нийтийн санаа бодолд дулдуйдан бүхнийг шийдэж, бүгдийг ноёлох гэсэн нэгэн хүчийг төрүүлжээ. Шинээр мэндэлсэн нийгмийн сүлжээний “дарангуйлагч” нь сэтгүүл зүйн нэр хүнд байр суурийг ганхуулахын зэрэгцээ мэргэжлийн стандарт, хэм хэмжээ, үнэт зүйлийг ч үгүйсгэж эхэллээ. Нэн ялангуяа “Зариг.мн”-ий сүүлийн үеийн хувь хүний амьдрал тойрсон хандалт өсгөгч контентууд үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх хүний төрөлх эрхийг үнэт зүйлээ болгосон хэвлэлийн эрх чөлөө, нийгмийн чухал, эрх ашигтаа хамааралтай бүхнийг мэдэх иргэний эрхийг үүрэг хариуцлагаа болгосон сэтгүүл зүйн стандарт, хэм хэмжээг буртаглалаа.

Нийгэм хүний амьдрал, асуудлыг шийдвэрлэх, эрх хариуцлагыг нь тогтоох гэж хууль эрх зүйн орчин, сэтгэл буяныг тэтгэх гэж шашин, мэдлэг боловсрол олгох гэж сургууль байдгийн адил үнэнийг тогтоохын төлөөх нийгмийн мэтгэлцээнийг хөтлөх, бодит баримт, учир шалтгаант үндэслэлийг түгээх гэж сэтгүүл зүй үүсэж, төлөвшсөн хэрэг. Тиймээс ч

үзэл бодол, хэвлэлийн эрх чөлөө бол иргэний эрх дарх болохоос сэтгүүлчийнх биш, асуудал сорилтыг шийдвэрлэгч нь хүн, нийгэм болохоос мэдээллийн сайт биш гэдгийг хүлээн зөвшөөрөх цаг болжээ. Мэдээлэл баримтын үнэ цэн гэдэг ч юмс, үзэгдэл, үйл явдлын бодит байдлын хангалттай бус, балархай үеийн эргэлзээ, үл мэдэхүйг тодотгох, үнэнийг олох зөв мэтгэлцээнд дэм болсноор тодорхойлогддог. Ингээд дээрх онол үзэл баримтлалын хүрээнд, асуудлыг илүү тодорхой өгүүлэх зорилго дор “зариг.мн” сайтыг үүсгэн байгуулагч Н.Өнөрцэцэгийн 2023 оны 10-р сарын 17-ны өдөр Г.Ганжаргалын амь насаа алдсан хэргийн талаар гэрч Батбаяр болон гэргий Отгонцэцэг нартай хийсэн 1 цаг 23 минутын ярилцлагад шүүмж саналаа бичлээ.

Ярилцлагыг зорилго бүхий харилцан яриа хэмээн тодорхойлдог. Зорилго гэдэгт тухайн асуудал эсвэл хүний тухай судалгаатай байж шалтгаан, учир холбогдол, үр дагавар зэрэг мэдэх, тодруулах, тайлбар авахын төлөөх үнэ цэнтэй яриа өрнүүлэхийг, харилцан яриа нь сэтгүүлчийн бат ноттой баримт, мэдээлэлд түшиглэн байр суурьтайгаар хандахыг багтаан үздэг. Өөрөөр хэлбэл ярилцлага нь хэрүүл маргаан эс бөгөөс бялдуулчлал бус үнэнийг тодруулах зорилго дор мэтгэлцэж буй үйл, харилцааг хэлдэг. Мэдээж нийгмийн эрх ашиг, ёс суртахуун, соёлыг дээдлэх ёстой. Ярилцлага хийх, бичлэгээ боловсруулах, нэвтрүүлэг бүтээл “бүтээгдэхүүн” болгох гээд мэргэжлийн стандарт хэм хэмжээнд нийцүүлсэн, олон нийтийн мэдээлэл авах эрэлт, ойлгох төвшин, хэм хэмжээнд нийцсэн шаардлагыг ч дагах ёстой. Сэтгүүл зүйн бүтээл

бүхэн цаг хугацаа, зохиомж, илэрхийлэл, ур чадвар, мэдлэг, мэргэжлийн шалгууртай байдаг нь ч олон нийт, хэрэглэгчээ дээдлэх цорын ганц зарчимд үйлчилдэгт оршино.

**Н**.Өнөрцэцэгийн ярилцлагын нэвтрүүлгийн эхлэл нь хань нөхрөө алдсан бүсгүйн хүүгийнхээ ааваа хүлээсэн сэтгэлийн тухай яриагаар эхэлжээ. Үзэгчийн сэтгэл зүй, анхаарлыг өдөөхөд хангалттай “зангууг шидэж” ярилцлагыг үзэх сонирхол, хүслийн суурь бэлэн болов. Гэхдээ тогтож шүүвэл үзэгчдэд “талийгаачийн алуурчин бол хамт явж байсан Батбаяр юм” гэсэн ярилцлагын зорилгынхоо тулгалт, дайралтын эхлэл ажээ. Мэдээж энэхүү сэжиглэл, баттай бус хардлага нь ярилцлагын зорилго болох ёсгүй төдийгүй дээр өгүүлсэн зарчим, хэм хэмжээг илтэд зөрчиж байна. Ингээд нэвтрүүлгийн эхний 16 минут ярилцлагын өрөөг нээх, бэлтгэх, ярилцагсад суух, танилцах, хэрэгт шууд хамааралгүй асуудлаар талийгаачийн эхнэр болон Батбаяр нарын маргаан хэрүүлээр үргэлжлэв. Энэ хугацаанд сэтгүүлчийн ярилцлагыг хөтлөх, асуудлын гол өнцөг, үндэслэлийг тодотгох зэрэг үүрэг, оролцоо үгүй, сэтгэл зүйн гүн хямралд орсон бүсгүй, хардлага сэрдлэгт бухимдсан эмч нарын хэрүүлийг сонсох төдийгөөр өнгөрөв. Тэр ч бүү хэл “хамт дагуулж ирсэн талийгаачийн эхнэрийн нэрийг мэдэхгүй “Хэн билээ” “Энэ хүнийг таньж байна уу” зэрэг асуулт тавьж, ярилцлага авахаар ирсэн хүнээ “Та сэтгэл зүйн хувьд зүгээр үү” “Яриа өгөхөд зүгээр үү” хэмээн зөвшөөрөл авч байв. Энэ бол мэргэжлийн бүү хэл энгийн яриа харилцаанд ч үл нийцэх үйлдэл мөн. Ярилцлага эхнээсээ л ямар ч баттай баримт, судалгаагүй, нөгөө талаас

эмчийг яллах гэсэн явцуу, ёс зүйгүй тулгалтаар өрнөж, хань нөхрөө алдсан бүсгүйн зовлонг сайтынхаа хандалтын тоог өсгөх “хэрэгсэл” ээлжит нэгэн “үзүүлбэр” болгосон нь илт болов. Ярилцлагын агуулга бүхэлдээ бүсгүйн хямарсан сэтгэлийн сэжиг хардлагын тулгалтаар дуусаж байгаа нь ч нэг талаас байцаалт, нөгөө талаас хоёр хүний хэрүүлийг дамжуулж буй үйлдэл хэмээн дүгнэхэд хүргэж байна.

Ийнхүү яриа (хэрүүл) эхлээд 20-иод минут өнгөрсний дараа сэтгүүлчийн асуулт эхлэв. Гэвч сэтгүүлч 12 минутын турш талийгаачийн зургийг харуулж асуулт асуух эсэх талаар маргав. Ярилцагч эмч Батбаяр зураг харахгүйгээр асуултад хариулъя гэснээс үүдэн “яагаад айгаад байгаа юм, юунд цочоод байна, би бол найз нөхөд ойр дотынхныхоо цогцсын зургаас айхгүй, хоолойнд байгаа хоёр ормыг харж байна уу, та эмч хүний хувьд энэ зургийг хараад талийгаач унаад амиа алдсан гэхэд итгэх үү, сохор тэнэг хүн хараад ч мэднэ, та сэтгэл заслын эмчилгээнд явсан байна лээ, энэ зураг дээр байгаа хүн найз чинь мөн үү, ямар санагдаж байна” зэргээр 12 минутын яриа өнгөрөв. Нийтдээ зураг харах талаар 13 удаа асууж, дээшээ харсан цогцсын зураг, боолгуулж амиа алдсан болон хоолойн ормын талаар 9 удаа онцолжээ. Тэр бүү хэл зургийг бариулж асуулт асуувал, бодитой ярилцлага болох талаар өөрийн хүсэлтээ тулгаж, эсрэг талдаа сэтгэл зүйн цохилт өгөх гэж оролджээ.

**Ү**зэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө иргэнийх, мэдээлэл түгээх, мэдэх эрх бол нийгмийн зайлшгүй эрэлт болохоос сэтгүүлчийн эрх мэдэл давуу тал биш. Энэ үүднээсээ иргэн хүн сэтгүүлчийн асуултад хариулахгүй байх эрхтэй.

Нэн ялангуяа хувийн амьдрал, төрөлх эрхийнхээ хүрээнд хариулахгүй байх эрхтэй. Харин албан тушаалтан хариулт өгөх үүрэгтэй. Гэхдээ иргэний мэдэх эрхийн хүрээнд, нийгмийн эрх ашгийн төлөө хариулт өгөх үүрэгтэй. Тиймээс ч үзэл бодлын эрх чөлөөний зорилго нь үнэн, арга зам нь эргэцүүлэн дүгнэхүй, үр нөлөө нь нийгмийн сайн сайханд оршдог. Ийм ч учраас бид хэн нэгнийг ялд тулгах, үндэслэлгүй сэжиг, тулгалтаар дайрах нь хэвлэлийн эрх чөлөөний үнэ цэн бус харин ч хор гэж үзэх ёстой. Үнэхээр ийм ёс бус, мэргэжлийн бус хандлага үйлдэл, газар авбал, харин ч төр, эрх баригчид хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах таатай шалтаг “тайлбар” болох нь ойлгомжтой. Үнэхээр ч сэтгүүлзүй нь мэргэжлийн, бие даасан байж сая нийгмийн итгэл, нэр хүндийг олсноор эрх мэдэл, засаглалын төвшинд үнэлэгдэнэ.

Ярилцлагын үлдсэн 55 минут хань нөхрөө алдсан бүсгүйн 7 сэжиглэлд хариу авахад зориулагджээ. Үүнд хэрэг болсон шөнө нөхрийг нь унтсан эсэхийг яагаад шалгасан, цогцсыг шууд таньсан эсэх, шилний хагархай байсан эсэх, гэр бүлийнхнийг хэрэг болсон газар хүргэхдээ зориудаар төөрсөн үү, хэрэг гарсан өрөөг цэвэрлүүлэх шалтгаан, талийгаач 4 давхраас унахдаа яагаад доод талын тагтан дээр унаагүй вэ, бор дугтуйтай зүйл дамжуулсан эсэх зэрэг баримт нотолгоогүй, сэтгэгдэл, төсөөлөл төдий асуултыг Батбаяраас шалгаав. Хэргийн гэрчээр татагдсан Батбаяр ч боломжийн хариулт өгч хамт явсан нэгнээ согтуу учраас харж шалгасан, зам төөрсөн нь анх удаа газарчилж явснаас будилсан, талийгаачийн задлан хийхэд гэр бүлийнхэнтэй хамт байж байгаад аймгаас хэрэг болсон

газар очихдоо цэвэрлэх нь зөв гэж бодсон, бор дугтуйтай зүйл өгч аваагүй, АТГ шалгуулсан зэргээр хариулжээ.

Энэхүү талийгаачийн эхнэр болон Батбаяр нарын ярианд (хэрүүлд) хэргийн учир шалтгааны талаарх анхаарч үзвэл зохих шинэ санаа, нотлох баримтын үнэ цэнтэй нэг ч үг, тайлбар үгүй бөгөөд харин ч төгсгөлд нь хамтдаа эмгэнэлт үйл явдлын үнэн мөнийг олохын төлөө бололцоотой бүхнийг хийх хэрэгтэй гэсэн саналд нэгдэв. Гэтэл сэтгүүлч Батбаярыг сургуулийн захирал болсон асуудлыг талийгаачтай албан тушаалын өрсөлдөөн байсан, нэр бүхий УИХ-ыг гишүүний сонгуулийн сурталчилгаанд явсан гэсэн таамаглалтай холбон ярилцлагын үндсэн сэдэв асуудлаас хөндийрч “хадуурав”. Энэхүү үйлдлээрээ сэтгүүлч Н.Өнөрцэцэг маргаанд ямар ч аргаар зөвхөн зөвдөж үлдэх, хуурамч ялалтад хүрэх гэж буй нь нотлогдоно. Үүнийг эртний Грекийн их сэтгэгч Аристотель “Уран илтгэхүйн ухаан” бүтээлдээ эрисч хэмээн шүүмжлээд “энэ оюун дүгнэлт бол тухайн (зүйлийг) судлах аргад нийцдэггүй атлаа (зохих) ур чадварын нь хэв ёсоор хийгдсэн мэт санагдуулдаг паралогизм (логикийн алдаа) юм гэжээ. Аристотель “...эристика нь маргаанд шударга бус арга хэрэгсэл хийж буй тэмцэл юм... зөвхөн ялахын төлөө хэл амаа билүүдэн маргалдагсад бол эрисчүүд юм, харин ашиг хөөж алдарших хэмээн дээрх маягаар аяглагчид нь софичууд (софист) юм гэсэн нь бий. Үнэхээр ч Н.Өнөрцэцэгийн аливаа асуулт, маргаан нь эрист төдийгүй цаад мөн чанар, зорилго софич хуурамч, мэргэн үгээр олз ашиг нэр хүнд хөөж буйн жишээ билээ

«

**Энэхүү үйлдлээрээ сэтгүүлч Н.Өнөрцэцэг маргаанд ямар ч аргаар зөвхөн зөвдөж үлдэх, хуурамч ялалтад хүрэх гэж буй нь нотлогдоно. Үүнийг эртний Грекийн их сэтгэгч Аристотель “Уран илтгэхүйн ухаан” бүтээлдээ эрисч хэмээн шүүмжлээд “энэ оюун дүгнэлт бол тухайн (зүйлийг) судлах аргад нийцдэггүй атлаа (зохих) ур чадварын нь хэв ёсоор хийгдсэн мэт санагдуулдаг паралогизм (логикийн алдаа) юм гэжээ. Аристотель “...эристика нь маргаанд шударга бус арга хэрэгсэл хийж буй тэмцэл юм... зөвхөн ялахын төлөө хэл амаа билүүдэн маргалдагсад бол эрисчүүд юм, харин ашиг хөөж алдарших хэмээн дээрх маягаар аяглагчид нь софичууд (софист) юм гэсэн нь бий. Үнэхээр ч Н.Өнөрцэцэгийн аливаа асуулт, маргаан нь эрист төдийгүй цаад мөн чанар, зорилго софич хуурамч, мэргэн үгээр олз ашиг нэр хүнд хөөж буйн жишээ билээ**

»

(зүйлийг) судлах аргад нийцдэггүй атлаа (зохих) ур чадварын нь хэв ёсоор хийгдсэн мэт санагдуулдаг паралогизм (логикийн алдаа) юм (Аристотель, "Уран илтгэхүйн ухаан" Орч,Б.Даш-Ёндон , 2009) гэжээ.

Аристотель “...эристика нь маргаанд шударга бус арга хэрэгсэл хийж буй тэмцэл юм... зөвхөн ялахын төлөө хэл амаа билүүдэн маргалдагсад бол эрисчүүд юм, харин ашиг хөөж алдарших хэмээн дээрх маягаар аяглагчид нь софичууд (софист) юм гэсэн нь бий. Үнэхээр ч Н.Өнөрцэцэгийн аливаа асуулт, маргаан нь эрист төдийгүй цаад мөн чанар, зорилго софич хуурамч, мэргэн үгээр олз ашиг нэр хүнд хөөж буйн жишээ билээ. Аристотелийн өөр нэгэн энэхүү ярилцлагатай холбоотой дүгнэлт нь өрөвдөхүйн тухай бөгөөд... мөрөөрөө байсан хүнд дайрсан гай зовлонг, бидэнд өөрсдөд маань юм уу эсхүл бидний хэн нэгэнд дайралдах, тэхдээ бүүр ойртоод ирчихсэн мэт санагдах (гай зовлонг) хараад үүсдэг сэтгэл өвдөхүй” (Мөн зохиол тал 122,

2009) юм гэжээ. Үнэхээр ч үхэл хагацал өрөвдөхүйг үүсгэдэг, хэний ч болов сэтгэл зүйд хүчтэй нөлөөлдөг мэдрэмж төсөөлөл бөгөөд энэхүү хүний жудаг ёсыг хэрэглэгчдийн хандалтыг өсгөх зорилгоор ашиглаж буй нь зөв зүйл биш ээ.

**С**этгүүл зүйн бүтээл, зохиомж талаасаа 83 минут үргэлжлэх нэвтрүүлгийн 28 минут нь ярилцлагын зорилгод үл нийцэх хоёр талын хувь хүмүүсийн маргаан, сэтгүүлч цогцсын зургийг харуулж асуулт тавих санал тойрсон тулгалт, үлдсэн хугацаа нь талийгаачийн эхнэрийн сэжиг таамагт төвлөрч, бодит баримт, үндэслэл үгүй, хэрэгт холбоотой чухал санаа, нотолгоогүй, сэтгэл зүйн гүн хямралд авсан бүсгүйн хардалт, төсөөлөлд зориулагджээ.

Ярилцлагын төсгөлд ярилцагч бүсгүй нь эмч залуугийн гар утсыг байнга шалгаж үзэх хүсэлт, ажлын 8 цаг дэргэд байх тухай заналхийлэл үзүүлж буй нь ч сэтгэл зүйн хямралд автсан хүний үг, үйлдэл билээ. Түүнчлэн сэтгүүлч “Та яагаад задланд орж юуг будилуулаад байна” “Үхсэний хохь амьдын зол болж байна” “Эмч нарын хэрэг ямар хэцүү юм бэ, толгой өвдчихлөө” зэрэг үгээр ярилцагч хүнээ дарамталж байснаа шүүх цагдаа яаралтай үнэн зөвийг тогтоох биз ээ хэмээн ойлгомжгүй, зорилгогүй бас “мэдээжийн зүйлийг мэргэн санаа болгон” төгсгөжээ. Ер нь энэ ярилцлагыг үзэж суухад цагдаагийн газрын байцаалт эсвэл гомдож цөхөрсөн бүсгүй ба хардлага сэрдлэгт өртсөн залуу хоёрын хувийн яриа өрнөөд байна уу гэмээр сэтгэгдэл төрж байлаа. Гэхдээ хамгийн гол нь ямар ч мэдээлэл, хэрэгт холбоотой санаа үндэслэл, үгүй хоцорч байгаад нэвтрүүлгийн чанар, сэтгүүлчийн ур

чадвар муу болжээ хэмээн дүгнэхэд хүргэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд даяар нийгмийн сүлжээ нь хүмүүсийн харилцааны тэргүүлэх орон зай болсныг ашиглан зарим нэг сайт хэрэглэгчийн хандалтыг татах зорилгоор хувь хүний амьдралын зовлон, бэрхшээлийг дэлгэн, олны анхаарлыг өдөөх гэсэн зүй бус үйлдэлдээ хэт хөтлөгдсөнөөр сэтгүүл зүйн энгийн хэм хэмжээг зөрчиж, цаашилбал түүний нэр хүнд, үнэт зүйлийг үгүйсгэх нөхцөл байдалд хүргэж байгааг “зариг.мн”-ы заримдаглал нотолж байна.

Нөгөө талаар Аристотель “Топика” зохиолдоо “Уран илтгэхэд чадвартай хүн (ярилцлага бол мэтгэлцээн юм. **зох**) гарт таарсан бүхнээр итгүүлэн үнэмшүүлж чадахгүй... уран илтгэгч бол бололцоотой бүхий л зүйлээс юуг нь ч үлдээгээгүйг мэдсэн цагтаа (судалгаа, мэдээлэлтэй, **зох**) өөрөөр хэлбэл энэ ур чадвараа хангалттай хэмжээгээр эзэмдсэн цагтаа л (ярилцлага хийх ур чадварыг “мэс заслын сэтгүүл зүй гэдэг.**зох**) итгүүлэн үнэмшүүлэх болно (Аристотель, Сочинения В 4-х томах, 1978) гэж онцолсон өдгөө ч үнэ цэнээ алдаагүй, сэтгүүл зүйн гол үзэл баримтлал, зарчим хэмээн дээдэлбэл таарна.

Ярилцлага бол зорилго бүхий харилцан яриа, хүний дотоод ертөнцөд нэвтрэх “мэс заслын сэтгүүл зүй” гэдгийг дахин тодотгосноор шүүмжээ төгсгөв.

#### Эшлэл

1. Аристотель. (1978). *Сочинения В 4-х томах*. М.
2. Аристотель. (2009). *"Уран илтгэхүйн ухаан"* Орч, Б.Даш-Ёндон . Улаанбаатар.

3. *Мөн зохиол тал 122.* (2009).

**Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Аристотель. (1978). *Сочинения В 4-х томах.* М.
2. Аристотель. (2009). *"Уран илтгэхүйн ухаан"* Орч, Б.Даш-Ёндон. Улаанбаатар.
3. Зариг.мн. Цогцосны зургийг харахаас айгаад байна уу? Яагаад?. Лайв. 2023.10.17.  
[https://www.facebook.com/watch/live/?ref=watch\\_permalink&v=545285174441817](https://www.facebook.com/watch/live/?ref=watch_permalink&v=545285174441817)

**Summary**

In this review, author criticizes "zarig.mn" website with the approach of "competition for the reach of websites- the narrow desire of users to solve their personal problems - the hidden funding of politicians". the creation of power is explained based on a live interview about doctor's death case.

**Keywords:** zarig.mn, interviews, social networks, role of journalism, ethics, effectiveness, confusion, reach.